

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2014-10-10/**

Ажлын хэсгийн 36 дугаар хуралдаан 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 08.30 цагт Уул уурхайн яамны хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Уул уурхайн яамны СТБГ-ын Уул уурхайн хэлтсийн дарга Б.Нэргүй, мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн яамны мэргэжилтэн Г.Зулай, БОНХЯамны мэргэжилтэн Саранцэцэг, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Оюунтуяа, Татварын ерөнхий газрын татварын ахлах байцаагч Ч.Батчимэг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Оюутолгой ХХК-ны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Алт үйлдвэрлэгчдийн холбооны ажлын албаны дарга С.Бүрэнтогтох, Бороо гоулд ХХК-ны татварын менежер Б.Ганхүлэг, татварын ахлах нябо П.Болормаа, Арева монгол ХХК-ны хуулийн асуудал хариуцсан захирал Б.Оюунчимэг, Саусгоби сэндс ХХК-ны Засгийн газар, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Алтанбагана, Петро матад ХХК-ны захирал Т.Амарзул, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч Н.Дорждарь, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Отгонсайхан, Ариун суврага хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын тэргүүн Л.Долгормаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 23 гишүүн оролцож ирц 70 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудитын корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав болон аудитын багийнхан, Адам Смит Интернэйшнл байгууллагын менежер П.Оюунбилэг, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хурлыг Уул уурхайн яамны Уул уурхайн хэлтсийн дарга Б.Нэргүй удирдан явуулав.

Б.Нэргүй: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хуралд ирвэл зохих 33 гишүүнээс 23 хүн ирсэн мөн хэдэн хүн ирж яваа учраас хурлаа эхлүүлэх саналтай байна.

Үүний дараа хурал удирдагч хурлын хөтөлбөр болон хуралдааны дотоод журмыг уншиж танилцуулснаар хурал эхлэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн явц, дунд хугацааны тайлан

Б.Осоргарав: Та бүхэнд намрын дунд сарын шинийн 17-ны билэгт сайн өдрийн мэндийг дэвшүүлье. ОУИТБС-ын 2013 оны 8 дугаар нэгтгэлийн тайланг бэлтгэх явцын болон урьчилсан тайланг та бүхэнд танилцуулъя. Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК, Англи улсын Харт Норс компанийн хамтарсан консерциум нь 2014 оны 7 дугаарын сарын 23-наас өнөөдрийг хүртэл хийсэн ажлын явцыг танилцуулж байна. Аудитын багт захирал миний бие, Харт Норс

компанийн зөвлөх, дотоодын багийн зөвлөх Н.Эрдэнэцог, ажлын багийн ахлагч бөгөөд ахлах аудитор Б.Мэндбаяр, багийн гишүүн орчуулагч, ахлах аудитор Дэлгэрмаа, ажлын багийн гишүүн бүртгэл санхүүгийн мэргэжилтэн Бямбаа, Төгөлдөр, Бямбасүрэн, Энхтүвшин, орчуулагч Ганчимэг нар ажиллаж байгаа. 2013 онд ОУИТБС-ын тайланг 1617 компани гаргаж, Засгийн газарт 1198 компани тайлангаа гаргаж өгсөн. Үүнээс 2013 оны нэгтгэлийн тайлангийн ажлын даалгаварт заасны дагуу 40 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн 250 компанийн тайланг нэгтгэж үр дүнг танилцуулж байна. (Нэгтгэл тайлангийн тоймыг хавсаргав.)

Б.Нэргүй: За дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн Б.Осоргарав захиралдаа баярлалаа. Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийг үүрч явдаг чухал салбар юм. Бид 8 дахь удаагийн нэгтгэлийн тайланг урьчилсан байдлаар сонслоо. Тайлангаас харахад анхны зөрүү нилээд багассан байна. Үүнээс харахад бидний хийж байгаа ажил нилээд үр дүнд хүрч байгаа юм байна. Цаашид Монголболгаргео ХХК, Угалзан цамхаг ХХК зэрэг 10 гаруй компани дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм байна.

Б.Осоргарав: Одоогоор шууд хариуцлага тооцох хууль эрх зүйн акт байхгүй байгаа. Ажлын албанаас ч ихээхэн ярьдаг.

Б.Нэргүй: Бид энэ асуудлыг хуульчилахаар хуулийн төсөл боловсруулсан, өнөө маргаашгүй УИХ-д өргөн барина. Аймгуудаас бас хэдэн аймаг хариуцлагагүй хандаж, анхан шатны тайлангийн материал дутуу өгсөн байна. Үүнд хариуцлага тооцох заалтууд хуулийн төсөлд тодорхой тусгагдсан байгаа. Ингээд хурлын дэгийн дагуу асуулт, хариултаа орьё оо, тайлангийн талаар асуулт байна уу.

П.Болормаа: Нэгтгэлийн тайлангийн урьдчилсан байдалтай танилцаж үзлээ. Тайлангийн 114-р хуудсанд манай компанийг аудиторийн тайлан ирүүлээгүй гэсэн байна. Манай компани нь нягтлан бодох бүртгэлийн стандартыг Монголд хэрэгжүүлэх тал дээр анхдагч байж ирсэн бөгөөд үүнийг сайн анхаарч техникийн алдаа гаргахгүй ажиллавал зүгээр юм. Мөн 129-р хуудсанд нөхөн сэргээлтийн мэдээлэлд бид уулын ажлын тайланг канондоод өгсөн боловч программаас шууд хэвлэхээр ойлгомжгүй харагддаг учраас бид аудитын ажилтанд энэ талаар тайлбар өгсөн боловч мэдээлэлд оруулаагүй байгаад гомдолтой байна. Манай компани нөхөн сэргээлтийн тал дээр бусад компаниудад үлгэр жишээ болж байдаг. Түүнчлэн 87-р хуудсанд 46 сая төгрөгийн зөрүүтэй гэсэн байна. Энэ нь гаалийн үйлчилгээний хураамж, Засгийн газрын тайлангаар НӨАТ-ийн илүү төлөлттэй байгаа. Энэ 2 нийлээд арай 46 сая хүрэхгүй байх, үүнийг залруулж болох байх гэж бодож байна.

Б.Нэргүй: За баярлалаа. Өөр асуулт, санал байна уу?

С.Бүрэнтогтох: Орон нутагт нөхөн сэргээлтийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд энэ тайлангийн нэгтгэлд орсон уу?

Б.Мэндбаяр: Өнгөрсөн жилүүдийн туршлагаас харахад компаниудаас гэрээний талаар өөрсдөөс нь судалгаа авахад буруу зөрүү мэдээлэх хүндрэл гардаг. Иймээс орон нутгаас нь авбал арай бодитой байдаг. Гэхдээ энэ тайланд цөөхөн орон нутгийн гэрээ орсон. Цаашдаа дараагийн тайланд нэгтгэгдээгүй гэрээг оруулах болно. Орон нутгаас ирүүлсэн гэрээ нь төдийлөн шаардлага

хангахгүй байсан. Аймагт хийсэн гэрээг Баянхонгор, Говь-Алтай аймгууд ирүүлсэн. Сумдын гэрээнүүд хийгдээгүй байгаа.

Б.Алтанбагана: 38-р хуудсан дээр манай компанийн хөрөнгө оруулсан замын байршлыг буруу бичсэн байна. Үүнийг засаарай гэж хэлмээр байна. 171-р хуудас дээр компаниудад үнэлгээ өгсөн байгаа ч зарим нь хоосон байгаа нь ямар үнэлгээ гэсэн үг вэ? Жишээлбэл манай компанид ямар ч үнэлгээ өгөөгүй байна. Бид ОУИТБС-д идэвхтэй оролцож, ажлын хэсэгт орж ажилладаг.

П.Болормаа: Манай компани ч гэсэн 2006 оноос эхлэн жил бүр ОУИТБС-ын тайланг гаргаж, үүнийг хэрэгжүүлэх тал дээр идэвхтэй ажилладаг. Гэтэл аудитын компанийн иймэрхүү техникийн алдаа, хариуцлагагүй байдлаас болоод бидний ажлын үр дүн байхгүй болж байна. Жишээлбэл: Энэ санаачилгын тайлан бидний хувьд маш чухал, ажлын маань үр дүнгийн нэгээхэн хэсэг байдаг. Бид Улаанбаатар аудит корпорацитай 3 дахь жилдээ хамтарч ажиллаж байна. Гэтэл жижиг сажиг алдаа их гаргадаг, гадаадын хөрөнгө оруулалттай компани заавал аудит хийлгэх ёстой байдаг, бид аудитын тайлангаа хүргүүлсэн байтал ирүүлээгүй гэх зэргээр ташаа мэдээлэл өгсөн байна.

Б.Мэндбаяр: Танайх аудитын тайлангаа ирүүлээгүй.

П.Болормаа: Би ажлын албанд аудитын тайлан болон бүх уулын ажлын тайлангуудаа канондож, хавсаргаад өөрийн биеээр аваачиж өгсөн.

Б.Осоргарав: Энэ бол урьдчилсан тайлан учраас залруулга, засвар хийх боломжтой.

Н.Баярсайхан: Улаанбаатар аудит 1 жил алгасаад аудитын нэгтгэл хийж байгаа. Иймээс компаниудын хандлага, төрийн байгууллагуудын хандлага, оролцоо ямар байна вэ? Ахиц байна уу? Өмнөх тайлангуудын дүгнэлт, зөвлөмжүүдийн хэрэгжилт байна уу? хоёрдугаарт, гэрээтэй холбоотой нилээд бэрхшээлүүд гарсан байна. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгоход татгалзах зүйлгүй, харин их зузаан байгаа учраас ил тод болгоход хэцүү байна, Засгийн газар зөвшөөрөхгүй байна гэжээ. Үүнийг Засгийн газрыг төлөөлж ирсэн Сумъяа гуайгаас асуумаар байна.

Б.Мэндбаяр: Өмнөх жилтэй харьцуулахад ахиц, дэвшил гарсан талаар тайландаа дурдсан байгаа. Тайланд байнга хамрагдаж байгаа компаниуд юмаа ойлгодог, нэгтгэлийн явцад үүссэн зөрүүн дээр хамтарч ажиллаж, шаардлагатай материал, мэдээллээр хангаж байгаа компаниуд олон байна. Мөн Ашигт малтмалын газраас лицензийн мэдээлэл авахад хүндрэлтэй байсан бол энэ жил санхүүгийн программаа шинэчилсэн учраас илүү хялбар байлаа. Бидний өгсөн зөвлөмжүүдээс хэрэгжсэн зүйл нилээд харагдаж байна. Өмнөх жилүүдийг бодвол энэ жил ажиллахад илүү хялбар байлаа. Одоогоор асуудалтай гурван компани л байна.

Н.Эрдэнэцог: 250 компанийн 8 нь газрын тосны компани байгаа. Эдгээр компаниудын “Бүтээгдхүүн хуваах гэрээ”-гээ ил тод болгох тухай албан бичиг явуулсан. Уг гэрээ нь маш том зузаан гэрээ байдаг юм байна. Компаниудын хэлж байгаагаар ийм зузаан гэрээг ил тод болгох нь хэцүү гэдэг. Харин Газрын тосны газрын цахим хуудаснаас загвар гэрээг харахаар энэ нь зөвхөн бүтээгдхүүн хуваахтай холбоотой биш хайгуул хийгээд түүний үр дүнд гарсан янз бүрийн

мэдээлэл агуулсан байдаг учраас түүнийгээ нууцлах зорилгоор гэрээг ил тод болгодоггүй юм байна. Яг үндсэн гэрээнд ямар заалт байгааг мэдэхгүй байна.

Б.Осоргарав: ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд ажлын алба болон иргэний нийгмийн байгууллагууд сайн ажиллаж байгаагийн үр дүнд уг тайланд компани, төрийн байгууллагууд ихээхэн ач холбогдол өгдөг болсон байна.

Э.Сумъяа: Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг яагаад ил тод болгохгүй байна вэ гэж Баярсайхан надад 2 удаа энэ асуудлыг тавьж байна. Газрын тосны газар энэ асуудлыг байгууллагын нууцлал гэж үзсэн юм байна лээ. Гэхдээ тэнд ганцхан нууцлалын асуудал байгаа, бусад нь бол загвар гэрээтэйгээ ойролцоо заалтууд байдаг. Бүтээгдэхүүн хуваах Засгийн газар, компанийн хувь өнөөдөр 40:60-аас, 60:40 хувь хүртэл эрс ялгаатай байгаа. Тухайлбал, зэргэлдээ хоёр талбайтай гэрээг нийтэд ил болгоход бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээ хоёр өөр байлаа гэж бодоход эднийд ийм хувиар гэрээлчээд, манайтай яагаад тэдэн хувиар гэрээлэв гээд асуулт гарах нь. Энэ нь юу гэсэн үг гэхээр 1990-ээд оны үеээс эхэлж хийсэн гэрээ нь 40:60 хувь байхад түүнээс хойш өрсөлдөөн бий болоод сүүлийн гэрээнүүдийн бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээ өсөөд явсан байгаа. Үүнийгээ л хамгаалж тайлбарладаг юм. Өөр ямар нэгэн нуух шалтгаан байхгүй гэж би ойлгож явдаг.

Г.Чагнаадорж: Петрочайна гэдэг компани яагаад тайлан, мэдээллээ өгдөггүй юм бэ? Мөн ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд Монгол улс төдийгүй дэлхийн хэмжээнд анхаарал хандуулаад байхад Гаалийн ерөнхий газар яагаад хойрго хандаад байдаг юм, жил бүр иймэрхүү асуудал яригдаж байна.

Э.Сумъяа: Гаалийн ерөнхий газрыг шууд хариуцдаггүй болохоор одоогоор хариулах боломжгүй байна. Энэ асуудлыг харин Үндэсний зөвлөлийн хурал дээр холбогдох сайд, дарга нарыг нь байх үед тавих хэрэгтэй байхаа. Улаанбаатар аудитыханд хандаж хэлэхэд тайлангаа сайн хянаарай, үг үсгийн алдаа их байна. Мөн компаниудын хэлсэн зүйлийг анхаараарай. Өнөөдөр хуулийн төсөл өргөн барихаар ажиллаж байна. Хуулийн төслийн ажлын хэсэгт Баярсайхан, Дорждарь, Ганбат нар байгаа. Нэмж орох хүн байвал хурлын дараа нэрээ өгч болно.

С.Бүрэнтогтох: Орон нутаг, компаниудын хооронд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж байгаа. Үүнийг тайлбарлаж байгаа орон нутаг, компани дээр ойлголтын зөрүүтэй асуудлууд их байна. Цаашид үүнийг сайжруулахаар Уул уурхайн яам, МУУҮАссоциаци идэвхтэй ажиллаж байна. Уул уурхайн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 101 сум байна. Нийгмийн хариуцлагын гэрээний тайланг авч байвал цаашдын үйл ажиллагаанд илүү үр дүнтэй байх болов уу.

Б.Баярмаа: Шинэ стандартын 3-ын 1 дээр нэрсийн жагсаалт авсан юм шиг байна. Нэрс нь байхгүй байна, үүнийг оруулах хэрэгтэй байх. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж оруулсан байх. Эдгээрийн зөвхөн нэрс л байгаа юу?

Ш.Цолмон: Бид 3 дугаар сард хуралдахдаа ярилцаад “бенефициар” гэж оруулахаар тохирсон байгаа.

Н.Эрдэнэцог: Компаниуд 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчийн нэрсийг гаргасан. Үүнийг харахад бүртгэлтэй, бүртгэлгүй, дотоод гадаадын компаниуд байна. Үүнийг ил тод болгохоор жагсаалтыг оруулах болно. Үүнээс илүү мэдээлэл

авах боломжгүй байна. Зарим нэг нь ил тод болгох боломжтой, зарим нь боломжгүй байна.

Б.Оюун: Нэгтгэлийн тайланд Петрочайна дачин тамсаг ХХК-тай холбоотойгоор 55,5 тэрбум төгрөгийн зөрүү гарсан байна. Тус компани түүхий тосны борлуулалтаа БНХАУ-д хийж, олсон орлогоосоо гэрээний дагуу манай улсад ногдох хэсгийг шилжүүлдэг. Тэгэхээр монгол дахь салбар компанийн нягтлан бодох бүртгэлд газрын тосны борлуулалтын орлого бүртгэгдэж явдаггүй байгаа. Газрын тосны тухай хуулийн шинэчлэн найруулгаар газрын тосны борлуулалтын бүх орлогыг манай улсын банкаар дамжуулах, монгол улсад ажиллаж буй салбар компанийнхаа нягтлан бодох бүртгэлд тусгана гэж заасан байгаа. Энэ 2013 оны тайлангийн зөрүүг Петрочайна компанийн хүмүүсийг дуудаад залруулаад өгчихье. Дараа жилээс ийм төрлийн зөрүү гарахгүй байх гэж бодож байна. За түрүүнд бүтээгдэхүүн хуваах гэрээг нийтэд ил тод болгох талаар асуухад Сумъяа гуай тайлбар өгсөн. Манай зүгээс бас нэмж тайлбар өгөхөд бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар манай вэбсайтад байгаа. Яг тэр загвараар л компаниуд гэрээгээ байгуулдаг ба хэдхэн заалт л өөр өөр байдаг. Тэдгээр заалтууд нь тухайн компанийн сонгон шалгаруулалт буюу тендерт өрсөлдөх чадварыг шууд илэрхийлдэг учир компаниудын хувьд нууцлах шаардлагатай болдог. Бид үүнийг хүртэл хуулийн дагуу ил тод, нээлттэй болгохоор ярьж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гуравдагч этгээдэд мэдээлэл задруулахаар бол гэрээний хоёр тал зөвшөөрсөн байна гэсэн байдаг. Тиймээс Газрын тосны газар дур мэдэн нөгөө талаасаа зөвшөөрөл авахгүйгээр шууд ил тод болгох боломжгүй байгаа. Иймд бүтээгдэхүүн хуваах гэрээнд шинэчилсэн хуулийн дагуу өөрчлөлт оруулахаар манай дээр ажлын хэсэг ажиллаж байна. Ирэх жилээс гэрээг нээлттэй болгох асуудал ч мөн гайгүй шийдэгдэх байх гэж найдаж байгаа.

Б.Осоргарав: Саусгоби сэндс ХХК, Бороо гоулд ХХК, Оюу толгой ХХК-иудаас түрүүнд техник алдаа гаргасан талаар саналаа өгсөн. Бид үүнийг эргэж магадлаад та бүхэнтэй эргээд холбогдоё. Манай ажилтнуудын зүгээс алдаа гарсан байж болох юм. Үүнийг нягтлах хэрэгтэй. Бороо гоулд ХХК аудитын дүгнэлтээ ажлын албанд хүлээлгэн өгсөн гэж байна. Гэтэл манай аудитор тэр дүгнэлт тайланг хүлээн аваагүй гээд байна. Тиймээс үүнийг бас нягталж үзье. Цаашид би ч гэсэн, манай ажилтнууд ч бас иймэрхүү техник алдаануудаа маш сайн хянаж байя, цаашид ийм алдаа давтахгүй байхад анхааръя. Та бүхнээс хүлцэл өчиж, талархсанаа илэрхийлэе.

Н.Баярсайхан: Байгаль орчны нөхөн сэргээлтэд хүлээн авдаг урьдчилгаа барьцаа төлбөрийн судалгаа гаргасан байна. Энэ их сайн зүйл. Гэхдээ үүнийг яаманд төлсөн дүн, суманд төлсөн дүнгээр нь ялгавал их сайн байна.

Б.Мэндбаяр: Энэ зөвхөн яаманд төлсөн дүнгүүд байгаа.

Н.Баярсайхан: Тэгэхээр энэ бол зөвхөн ашиглалтын компаниудын төлсөн төлбөр юм байна. Тэгвэл үүн дээрээ тайлбар хийж өгөх хэрэгтэй. Хоёрдугаарт, уул уурхайн үндэсний оператор гэсэн байна. Энэ компани юмуу? Эсвэл төрийн өмчит компани юмуу? Тайлангийн чанартай холбоотой нэг санал байна. Бид энэ тайланг олон нийтэд ашиглуулахын тулд гаргаад байгаа. Тиймээс тайлан ашиглах аргачлалын талаарх тайлбарыг, нэр томъёоны тайлбарын хамтаар тайлангийн өмнө оруулах хэрэгтэй. Гэрээг ил тод болгох шаардлага ОУИТБС-ын шинэ стандартад орсон, бид 2015 онд олон улсын баталгаажуулалтад ороход энэ бас нэгэн шалгах үзүүлэлт болно. Хэдхэн тоо ч гэсэн иргэдэд нээлттэй болох чухал

шаардлагатай байгаа учраас иргэний нийгмийн байгууллагууд гэрээг ил тод болгох шаардлагатай гэж үзэж байгаа.

Б.Батболд: Байгаль орчинтой холбоотой 2 асуудал байна. Нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй 190 гаруй компаниудаас 80 гаруй компаниуд нөхөн сэргээлт хийсэн байна гэсэн байна. Гэтэл нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөгүй 62 компани байна гэжээ. Уул нь бүх тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй байх ёстой. Энэ ямар учиртай юм бэ, үүнийгээ та бүгд маш сайн шалгаарай. Хэрэв тэдгээр компаниуд нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөгүй нь үнэн бол түүнд тусгай зөвшөөрөл өгч буй төрийн захиргааны байгууллагуудад асуудал яригдах байх.

Б.Нэргүй: За ингээд нэгдүгээр асуудлынхаа саналыг таслая. Өнөөдрийн бидний хуралдааны хамгийн гол асуудал бол ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайланг хэлэлцэх асуудал байлаа. Гишүүд их ач холбогдол өгч, санал хэлж оролцлоо.

I ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн явц, дунд хугацааны тайлантай танилцаж хангалттай гэж үзэв.

2. Тайлангийн шийдвэрлэгдээгүй зөрүү бүрийг дахин нягталж, шийдвэрлэх талаар ажиллаж, Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг тусган эцэслэн боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргаравд үүрэг болгов.

3. Үндэсний зөвлөлийн хуралдааныг энэ оны 11 дүгээр сарын сүүлчээр зохион байгуулахыг Ажлын албанд даалгав.

4. Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн гэрээт үнийн дүнгийн 80 хувийн төлбөрийг Улаанбаатар аудит корпораци ХХК, Харт Нойрс лтд компанийн хамтарсан консорциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 6 удаагийн Үндэсний нэгтгэл тайлангуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн дүгнэлт

Б.Нэргүй: За дараагийн асуудалдаа оръё. Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож Таныг дүгнэлтээ танилцуулахыг хүсье.

Г.Уранцоож: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Энэхүү Мониторингийн захиалагч ТАН эвсэл, гүйцэтгэгч нь Хүний эрх хөгжил төв, Зориг сан хамтарч ажилласан. Монгол Улсын ОУИТБС-ын 6 удаагийн нэгтгэл тайланд мониторинг хийсэн байгаа. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Нэргүй: За Уранцоож тэргүүндээ баярлалаа. Мониторинг тайлангийн зөвлөмж гэж тусад нь гарах юм байна. Нилээд чухал чухал зөвлөмжүүд өглөө. Энэ зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд ЗГХЭГ-ын ахлах референт Сумъяа гуай та бүхэнд танилцуулаад чөлөө аваад явсан буюу “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийг батлах ажилтай яах аргагүй холбоотой юм. Хэрэв хууль

батлагдвал түүнийг хэрэгжүүлэх журам, тогтоолыг боловсруулах ажил хийгдэнэ. Тэр үед нь харин эдгээр зөвлөмжүүдийг хаана нь хэрхэн тусгах, хэн юу юуг хариуцах уу гээд нарийвчлан хэлэлцэх байх, тэр үед илүү тодорхой болох болов уу гэж бодож байна. Одоо дэгийн дагуу санал, асуултдаа орьё, та бүхэнд санал, асуулт байна уу?

Н.Баярсайхан: Мониторингийн судалгаа хийж байхад Уул уурхайн яам, Уул уурхайн үндэсний ассоциаци хариу өгөөгүй гэж байна. Яагаад хариу өгөөгүй юм бол оо?

Д.Энхболд: Манайд тийм мэдээлэл авья гэсэн албан тоот ирээгүй.

Ч.Энхжаргал: Тайлан дээр яг тэгж бичсэн байсан л даа. МУУҮА албан тоот аваагүй гэсэн хариу ирүүлсэн байсан, УУЯ-ны хувьд мэдээлэл өгсөн гээд албан тоотыг хаасан байсан гэж байсан. Би энэ ажлыг дундаас нь авсан болохоор бас нарийн явцыг мэдэхгүй байна.

Н.Дорждарь: Цолмон гуайгаас асуулт асуух гэсэн юм. Ажлын хэсгийн хуралдаан эхлэхээс өмнө өмнөх хуралдаанаас ямар шийдвэр гарсан, түүний биелэлт, хэрэгжилт ямар явцтай байгаа талаар танилцуулаад явах талаар хэд хэдэн удаа санал тавьж байсан. Үүнийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл байгаа юм бэ? Та өөрөө ч мэдэж байгаа олон улсын удирдах хорооны хурлаар бас яг адил тухайлбал 10 хуралдааны өмнөх асуудал хэрэгжээгүй бол заавал ажлын хэсгийн хуралдаанд танилцуулаад явдаг байгаа. Ийм горимд шилжээд явахад юу нь болохгүй байгаа юм бэ?

Ш.Цолмон: За баярлалаа. Мониторингийн үйл явцад ажлын алба идэвхтэй оролцож, аль болох бүх тайлбар, мэдээллээ хуваалцаж, хамтран ажиллаж ирсэн. Энэ явцад бид нилээдгүй алдаа дутагдал байгааг олж харсан. Тэгэхээр энэ бол бидний үйл ажиллагааг сайжруулахад чухал чиглүүлэх баримт бичиг болох юм. Дорждарийн асуултанд хариулахад, бид ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу ажил хариуцаж авсан тухайн байгууллагад ханддаг. Та дараагийн хурлаар хариуцаж авсан ажлынхаа явцын талаар танилцуулга хийх үү гээд. Тэгтэл байгууллагууд бол үгүй гэдэггүй, за гэдэг. Гэхдээ яг ажлын хэсгийн хуралдаан болоход танилцуулдаггүй, ирдэггүй гээд олон асуудал байна. Ажлын алба бол тухайн байгууллагад хариуцлага тооцох эсхүл заавал танилцуул ч юмуу дарамт шахалт үзүүлэх эрх, чадамж байхгүй. Ерөнхийдөө нэг тийм урсгалаараа гэх нь ч хаашаа юм, өмнө үйл явц ингэж л явж ирсэн. Хэрэв тухайн ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийг ухаалагаар хэрэгжүүлээд явсан бол өнөөдрийн танилцуулсан зөвлөмжийн биелэлт өндөр байх байсан болов уу гэж хувьдаа бодож байна.

Н.Дорждарь: Та гэхдээ миний асуултанд хариулсангүй ээ.

Б.Батболд: Өнгөрсөн хурлын шийдвэр, зөвлөмжийг дараагийн хуралдаанд танилцуулах боломж ямар байгаа юм бол?

Ш.Цолмон: Би түрүүнд хэлсэн шүү дээ. Энэ бол оролцогч талуудаас шалтгаалдаг. Ажлын алба албан байдлаар, заримдаа албан бус байдлаар ханддаг. Гэхдээ хэрэгжилт байхгүй ийм байна.

Н.Дорждарь: Би энэ саналыг 2, 3 ч удаа тавьж байгаа. Би тухайн үедээ энэ асуудал шийдэгдлээ л гэж ойлгосон. Хурлын дарга ч гэсэн үүн дээрээ анхаармаар байна. Өмнөх ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт гээд дараагийн хуралдааны нэгдүгээр асуудал болгож оруулж ирээд, хэрэгжсэн бол хэрэгжсэн, хэрэгжээгүй бол хэрэгжээгүй гээд танилцуулах бололцоо бүрэн байгаа. Гол нь ажлын хэсэг өөрсдийнхөө гаргасан шийдвэрийн биелэлтийг бас хянаад явах хэрэгтэй байна. Энэ талаар ажлын хэсгийн дүрэмдээ оруулаад явуулж болохгүй юу?

Ш.Цолмон: Тэгье.

Б.Нэргүй: Саяны Дорждарийн хэлээд байгаа саналыг хэрэгжүүлэхэд болохгүй юм байхгүй ээ. Биелсэн бол биелсэн, биелээгүй бол яагаад биелээгүй гэсэн шалтгааныг ил тодоор танилцуулаад явахад болохгүй зүйл байхгүй. Гол нь ажлын хэсгийн хуралдааны чанар сайжирч, та бүгд энд суусны үр дүн гарна. Тэгэхээр сая Цолмон гуай за гэж байна, дараагийн хуралдаанаас эхлээд тэр хэлбэрт шилжээд явах байх.

Н.Баярсайхан: 6 удаагийн үндэсний нэгтгэл тайлангаас гарсан шийдвэрийн биелэлтэнд мониторинг хийх ажил их амаргүй ажил байлаа. Бид энэ ажлын үр дүнгээ Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах саналтай байна.

Б.Батболд: За мониторингийн судалгаа хийсэн байгууллагад баярлалаа. Миний санал бол Үндэсний зөвлөлд танилцуулахаас өмнө эхлээд Ажлын хэсэг энэхүү мониторингийн тайлангаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ямар боломж байгаа юм, үүн дээр ажиллавал яасан юм бэ? Тэгэхгүй бол бид эхлээд зарим нэг хэрэгжүүлэх боломжтой ажлыг хийгээгүй байж, шууд энэ байдлаар нь Үндэсний зөвлөлд танилцуулах нь үр дүн багатай байх гэж бодож байна.

Н.Баярсайхан: Зөвхөн компани, иргэний нийгмийн төлөөлөл санал хэлээд байх бас учир дутагдалтай байна. Энд суугаа төрийн байгууллагын төлөөллүүд ямар санал, бодолтой байгаа юм бэ?

Д.Оюунтуяа: Миний хувьд энэ ажлыг хүлээж аваад удаагүй байна. Урьд ямар зөвлөмж өгөгдөөд, ямар нь биелсэн талаар мэдээлэл алга байгаа тул одоогоор санал хэлэх боломжгүй байна. Ер нь бол манайтай холбоотой ажлуудын хэрэгжилт, биелэлт нилээд ахицтай явж байгаа гэж ойлгож байгаа.

Б.Нэргүй: За тэгэхээр Оюунтуяа ажилтайгаа шуурхай танилцаад яваарай. Хууль одоо батлагдвал дагаад дүрэм, журам боловсруулах ажлууд байна, түүнчлэн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд байгаа шүү. Мөн манай МУУҮА гүйцэтгэх захирал Г.Алгаа ассоциацийнхаа Ерөнхийлөгчөөр сонгогдож, Гүйцэтгэх захиралаар Д.Энхболд томилогдсоныг Та бүхэнд танилцуулая.

Ч.Батчимэг: За надад саяны танилцуулгын хураангуй тайланг өгсөнгүй. Гэхдээ илтгэгчийн ярианаас сонсоход хамгийн их давтагдсан тайлангийн маягтыг сайжруулах гэсэн зөвлөмж биелээгүй гэжээ. ОҮИТБС-ын тайлангийн 4, 5 дугаар маягтыг жил бүр шинэчлэн, сайжруулж ирсэн. Энэ бол хэрэгжээгүй биш, хэрэгжиж ирсэн ажил. Тэгэхээр миний хувьд Батболдын хэлсэн саналтай нэг байна. Мэдээж энэхүү мониторингийг тодорхой цаг хугацаанд, хүчин чармайлт гаргаж хийсэн байх. Гэхдээ бидний зүгээс зөвлөмж дээр тайлбар хийх ажлууд бас байгаад

байна. Учир нь ТЕГ-ын зүгээс ОУИТБС-ын тайлан бэлтгэх ажил дээр нилээд цаг хугацааг зарцуулдаг учир дараа нь тэр дэлгэрэнгүй тайланг харж байгаад хэрэгжээгүй ямар ямар ажил байгаа юм, зарим ажил магадгүй хэрэгжээгүй биш сайжруулаад явсан ажил байгаа. Тиймээс энэ тайланд сайжруулаад явсан ажил нь ямар ажил юм түүнийг бас оруулж өгөх хэрэгтэй гэсэн саналтай байна.

Г.Уранцоож: Цаг бага байсан тул тэр бүгдийг бас танилцуулж амжсангүй. Дэлгэрэнгүй тайлан дээр юу нь сайжирч ирсэн юм гэдэг талаар тусгасан байгаа.

Г.Зулай: Манай байгууллагаас мэдээлэл авахаар албан тоот ирүүлсэн байсан. Бид зохих тайлбарыг хийгээд, хариу хүргүүлсэн. Надад бас өнөөдрийн танилцуулгын хураангуй тайланг өгсөнгүй. Тэгэхээр бас яг ямар ажил нь хэрэгжээгүй талаар мэдэхгүй байна. Дэлгэрэнгүй тайлантай танилцаад эргээд хариу тайлбар өгье.

х.Саранцэцэг: Мөн бас адил саналтай байна. Ямар ажил хэрэгжээгүй талаар мэдээлэл алга байна. Тайлантай танилцаад хариу өгье.

Б.Нэргүй: За ингье ээ. ҮТЕГ, АМГ, ГТГ, Сангийн яам, Уул уурхайн яам, БОНХЯ өнөөдрийн хуралдаанд төрийн байгууллагуудыг төлөөлж оролцсон. ГЕГ-ын төлөөлөл ирээгүй юм байна. Сангийн яам үүн дээр анхаараарай. Цаашид хуралдаанд хоёр агентлагтайгаа оролцоорой. АМГ, ГТГ гэсэн манай хоёр агентлагийн нэг нь түрүүлээд явсан байна, нэг нь шинэ хүн байгаа юм байна. Тэгэхээр төрийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бид өөрсдөөсөө хамаарах ажлуудаа хийцгээе. Өнөөдөр иргэний нийгмийн байгууллагууд, компаниуд, мэргэжлийн холбоод санаачлагаараа мониторинг хийгээд биднээс биелэлтийг нэхэж, шаардаж байна. Бид биелэлтээ гаргаад, эргээд бусад оролцогч талуудаасаа биелэлт шаарддаг, харилцан уялдаатай ажиллах хэрэгтэй. За тэгээд хуралдаанд ирсэн төрийн байгууллагуудын төлөөллүүддээ баярлалаа, хуралдаа дуустал нь идэвхтэй оролцоорой.

Г.Уранцоож: Батболдын саналтай мөн адил байна. Ажлын хэсэг бас зөвлөмжийн биелэлт дээр ажиллах хэрэгтэй. Өнөөдөр бид 2013 оны нэгтгэл тайлантай танилцлаа. Аудитын компанийн зүгээс гэхдээ тодорхой зөвлөмж өгсөнгүй. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлаа энэ жилийн тайлангаас эхлээд явах нь зүйтэй. Ямар зөвлөмж нь давтагдсан байна, ямар зөвлөмжийг илүү тодорхой болгох уу, ямар нь хэрэгжих боломжтой юм, ямар нь хэрэгжих боломжгүй юм гэх зэрэг шүүлтүүр гаргах байдлаар Үндэсний зөвлөлд ямар зөвлөмжийг нь оруулах уу гээд Ажлын хэсэг эхлээд ажиллах хэрэгтэй. Хоёрдугаарт, мониторингийн бүтэн тайлан нь 10 гаруй хавсралт хуудастай түүн дээр бүх байгууллагуудтай яаж харилцсан, ямар тайлбар ирсэн гэх зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл байгаа. Түүнийг бид ажлын албанд хүргүүлье. Ажлын алба цааш нь гишүүддээ тараана биз ээ. Эцэст нь мониторингийн хугацаанд маш дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгч, бидэнтэй нягт хамтран ажилласан ажлын албанд талархсанаа илэрхийлмээр байна. Баярлалаа.

Н.Эрдэнэцог: Түрүүнд Уранцоож гуай аудитын нэгтгэл тайлангийн зөвлөмж хэсэг гарсангүй гэж байна. Бид урьдчилсан тайландаа бол эхний байдлаар зөвлөмжүүдээ оруулсан байгаа. Өнөөдрийн танилцуулгын хугацаа богино байсан тул бид танилцуулж амсангүй.

Б.Нэргүй: За Эрдэнэцог оо, Осоргарав гуай бидний зүгээс танилцуул хугацааг хангалттай тавьж өгсөн, гол зөвлөмжөө танилцуулалгүй, тойрч ярьса; байгаад таарсан. Дараа дараагийнхаа танилцуулгадаа цагаа зөв хуваарил байхыг хүсье.

Л.Долгормаа: Олон жил бид энэ тайланг ярьж байна, чухал бол чухал, а холбогдолтой бол ач холбогдолтой байгаа. Чухам юунд үндэслээд дахин дахин зөвлөмж өгөөд, тэр нь хэрэгжихгүй байна гэхээр нэг асуудал байгаа юм. Энэ бол сурталчилгааны асуудал. Жишээлбэл, өнөөдрийн мониторингийн ажил. Энэ ажлыг хийхэд маш хүндрэлтэй байсан байх. Нөгөө гуйна гэдэг гутамшиг, гуйлгана гэдэг гайхамшиг гэдэг шиг. За идэвхтэй хариу ирүүлдэг байгууллагууд ч байна, тэдгээрт талархах хэрэгтэй. Гэтэл ГЕГ мэдээлэл гаргаж өгөөгүй гэж байна. Яг нарийн ярьвал 2 албан тушаалтан мэдээ гаргаж ирүүлээгүйгээс улсын хэмжээний ажил саатаж байна. Энэ бол тухайн байгууллагын нэр хүндийн асуудал. Тэгэхээр ажлын хэсгийн гишүүд энэ том тайлангаас ямар үр дүн гарав, ямар байгууллага шуурхай ажиллав, ямар байгууллага хаалттай байв гэдэг талаар сурталчилаад яваачээ. Ер нь хүн нэр төрөндөө их хайртай байдаг учраас сурталчилгааг сайн хийж чадвал бидний ажилд сайнаар нөлөөлнө гэж бодож байна.

Б.Нэргүй: Чухал санал байна. Өнөөдрийн хуралдааны хэлэлцсэн асуудлын талаар олон нийтэд мэдээлэх нь их чухал. Сэтгүүлчдийг өнөөдрийн хуралдаанд оролцуулж бас мэдээлэх хэрэгтэй байсан байна. Та бүгд бас хэвлэл мэдээллээр хуралдааны талаар олон нийтэд сурталчилаарай. За хоёрдугаар хэлэлцсэн асуудлын шийдвэрийн тухайд Уранцоож тэргүүн шийдвэрийн төслөө ажлын албатай хамтран бэлдээд өгөөрэй. Дараагийн Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах тул шийдвэрийн төсөл чухал шүү. За ингээд дараагийн асуудалдаа орьё.

II ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОУИТБС-ын 6 удаагийн Үндэсний нэгтгэл тайлангуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн дэлгэрэнгүй тайлантай судалгаанд хамрагдсан байгууллага бүр нарийвчлан танилцаж, мониторингийн дүнг хүлээн зөвшөөрч буй эсэх, шаардлагатай бол нэмэлт тайлбарыг Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоожид 10 дугаар сарын 24-ны өдрийн дотор гаргаж өгөх, биелээгүй зөвлөмжийн тайлбарыг Үндэсний зөвлөлд танилцуулахад бэлтгэхийг судалгаанд хамрагдсан байгууллагуудад үүрэг болгов.

2. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас ирсэн нэмэлт тайлбар, Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг тусган Монгол Улсын ОУИТБС-ын 6 удаагийн Үндэсний нэгтгэл тайлангуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайланг дахин боловсруулж, Үндэсний зөвлөлд танилцуулахад бэлтгэхийг Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоожид үүрэг болгов.

3. Мониторингийн дүнд үндэслэн Үндэсний нэгтгэл тайлангаар өгөгдөж буй зөвлөмжийг хэрэгжүүлэх санал боловсруулах, холбогдох журамд өөрчлөлт оруулах үүрэг бүхий цомхон ажлын баг бүрдүүлж, 10 дугаар сарын 24-ны өдрийн дотор томилохыг Ажлын хэсгийн ахлагч (орлогч)-д даалгав

4. Дээрх ажлын баг нь жил бүрийн Үндэсний нэгтгэл тайлангаар өгөгдөж буй зөвлөмжийг хэрэгжүүлэх санал боловсруулах, өмнөх тайлангуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн шаардлагатай арга хэмжээ авах тухай

шийдвэрийн төслийг боловсруулан Ажлын хэсгийн болон Үндэсний зөвлөлийн хуралдаанд тогтмол танилцуулж байхаар тогтов.

5. Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийн явцын талаар дараагийн ажлын хэсгийн хуралдаанд тогтмол танилцуулж байхыг Ажлын алба /Ш.Цолмон/-нд зөвлөв.

6. Ажлын хэсгийн хуралдаанд Сангийн яам, Уул уурхайн яам нь харъяа агентлагийн хамтаар оролцож байхаар тогтов.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: “ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох” олон талт хэлэлцүүлгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай

Н.Баярсайхан: Төлсөн авснаа нийтэл иргэний нийгмийн эвсэл энэ санаачлагыг яаж үр дүнтэй хэрэгжүүлэх, талуудтай яаж хамтарч ажиллаж, зөвшилцөлд хүрэх вэ гэдэг талаар ажиллаж байдаг. Тэгэхээр зөвхөн хянаад, мониторинг хийгээд зөвлөмж өгөөд явах бус аль болох хэрэгжилтийг урагш ахиулахын төлөө бид ажиллаж ирлээ. Энэ хүрээнд маш олон төрлийн сургалт, мониторинг, дүн шинжилгээний ажлуудыг хийдэг. За энэ ажлуудыг хийхэд Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн гэх зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцааг авдаг. За тэгээд та бүхэнд ТАН эвслээс зохион байгуулсан ажлуудыг танилцуулая. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Нэргүй: Цөөн хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулах санал гаргаж байна. Үүнийг миний хувьд дэмжиж хүлээн авч байна. ТАН эвслээс шийдвэрийн төслөө боловсруулаад зохицуулагчдаа өгөөрэй. За ингээд саяны танилцуулгатай холбоотой асуулт, санал байна уу?

С.Бүрэнтогтох: Иргэний нийгмийн байгууллагуудын орон нутагт ажилласан тухай танилцуулгыг сонслоо. Ажлын албанаас бас энэ жил Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай, Баянхонгор аймгийн Галуут, Хэнтий аймгийн Норовлин, Дорнод аймгийн Баяндун сумдад ОУИТБС-ын уулзалт, өдөрлөг зохион байгуулж орон нутагт ажиллаад ирлээ. Уул уурхайн салбарын хууль эрх зүйд тодорхойлсноор уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тухайн орон нутгийн ард иргэдээс санал авдаг болсон. Та бүгдийг Оюу толгой, Бороо гоулд, Таван толгойн нүүрсний уурхай ажилладаг орон нутагт ажиллахдаа энэ хүрээнд ажилласан байх гэж бодож байна. За бусад аймаг, орон нутгийн хувьд иргэний нийгэмтэй холбоотой хүндрэл, бэрхшээл тулгараад байна. Жишээлбэл, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр орон нутагт байгаль хамгаалах чиглэлийн олон талт зөвлөлүүд байгуулагдсан байдаг. Эдгээр зөвлөлүүд хууль ёсны зөвшөөрөлтэйгээр ажиллаж байгаа компаниудын эсрэг газар нутгаа хөндүүлэхгүй, малын бэлчээр байхгүй боллоо ч гэх юмуу эсрэг үйл ажиллагаа явуулж байдаг. Дээр нь тухайн орон нутгийн Засаг дарга, удирдлагууд Азийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг гэх зэрэг төслөөс хэрэгжүүлдэг сурталчилгаа, үйл ажиллагааны үр дүнд тэд бичил уурхай эрхлэгчдийг дэмжих ёстой юм байна, байгаль хамгаалах ёстой юм байна гээд нөгөө хууль ёсны зөвшөөрөлтэйгээр, төрөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагааг хаах, боох явдал хаа саагүй газар авч байна. Үүний нэг тод жишээ бол Баянхонгор аймаг байна. Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй компаниуд үйл ажиллагаа нь зогсоход хүрээд өөрсдөө нөхөн сэргээлтийн гэрээ байгуулж эхлээд байна. Ганц

Баянхонгор ч биш, Сүхбаатар, Увс аймагт мөн адил, олон нийтийн сүлжээгээр бас энэ талаар мэдээ явж байна. Орон нутгийн иргэд, удирдлагыг компаниудын эсрэг турхирах явдал гарч байна. Үүн дээр иргэний нийгмийн байгууллагууд дотоод харилцаа холбоо, сүлжээ гэж байдаг байх түүгээрээ дамжуулж анхаарал хандуулаачээ гэж хүсэх байна. Хоёрдугаарт, сая зөвлөмжид дурьдаж байна. Мэргэжлийн холбоодын зүгээс тайлан гаргадаггүй, хариуцлагагүй ханддаг компаниудтай тулж ажиллаж болно гэдгээ илэрхийлье. Гуравдугаарт, орон нутагт ажиллахад дан ганц ил тодын асуудлаар бус салбарын хууль, эрх зүйн орчныг сурталчилах, орон нутгийн иргэд, удирдлагуудыг мэдээллээр хангах, хуулийг нэг мөр ойлгох ажлыг хийх хэрэгтэй байна. Энэ ажлыг төрийн байгууллагуудын зүгээс хангалттай хийхгүй байгаатай холбоотойгоор уул уурхайн салбар албан бус хэлбэрт шилжих маягтай, албан ёсоор үйл ажиллагаа явуулах чадамжгүй болж байна. Тодруулбал, ажлын албанаас зохион байгуулсан удаа дараагийн орон нутгийн уулзалтад Уул уурхайн яам, Татварын ерөнхий газраас бусад төрийн байгууллагууд оролцсонгүй. Төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангадаг эрх бүхий аль байгууллага байдаг юм, ЗГХЭГ юмуу холбогдох байгууллага анхаараачээ гэж хүсэх байна. Ажлын хэсэгт орж ажиллаж буй төрийн байгууллагууд эсхүл орон нутагт ажиллах, хууль сурталчилах тал дээр ач холбогдол өгч, идэвхтэй ажиллаачээ гэж хүсэх байна.

Б.Нэргүй: За баярлалаа. Чухал санал хэлж байна. Салбарын үйл ажиллагаанд санаа тавьж, хэвийн явуулахад нь учраад буй саад бэрхшээлийг сааруулах талаар санал хэллээ. Иргэний нийгмийн байгууллагууд дурьдсан хүндрэлийн талаар сайн мэдэж байгаа байх, та бүхэн бас мэргэжлийн холбоодоос гаргаж буй саналд ач холбогдол өгч, ажил хэрэг болгоход идэвхтэй хамтран ажиллахыг хүсч байна. Эдийн засагт чухал нөлөөтэй салбар болох уул уурхайн салбар, тэр дундаа валютын нөөцийг өсгөх чухал нөлөөтэй алтны үйлдвэрлэл хөгжвөл долларын ханш буурах, өргөн хэрэглээний барааны үнэ ханш буурах гэх зэрэг та бидний л амьдрал тустай юм. Тэгэхээр иргэний нийгмийн байгууллагууд хамтарч ажиллах байх гэж бодож байна. МБОИЗ нь 700 гаруй байгууллагуудыг нэгтгэдэг. Тэгэхээр цаашид ИНБ-ууд манай мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах нь олон талын ач холбогдолтой билээ.

Ш.Цолмон: Төрийн байгууллагуудын оролцооны талаар Бүрэнтогтох чухал санал хэллээ. Бид Заамар, Бүрэгхангай, Галуут, Норовлин, Баяндун сумдад ажиллаа. Цаашид Дорноговь, Дундговь, Дархан Уул, Орхон, Төв аймгуудад ажиллахаар бэлтгэж байна. Ажлын албаны зүгээс орон нутагт ажиллах хуваарь, хөтөлбөр, удирдамжийг боловсруулж холбогдох төрийн байгууллагуудад төлөөлөл томилж ажиллуулах тухай албан тоотыг хүргүүлдэг. Одоогийн байдлаар ТЕГ тогтмол оролцож байна. Бусад төрийн байгууллагууд оролцоо хангалтгүй байгааг хэлэх нь зүйтэй. Дараа дараагийн орон нутгийн уулзалтад яамдууд идэвхтэй оролцохыг хүсэх байна. Учир нь орон нутагт хууль боловсруулдаг, хэрэгжүүлдэг, бодлого боловсруулж, хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын мэдээллийг их шаардах юм. Хоёрдугаарт, Бүрэгхангай, Заамар сумдад салбар зөвлөлийг байгуулаад байна. Галуут сум энэ 10 сард байгуулахаар тогтсон. Норовлин, Баяндун сумд энэ ондоо багтаад байгуулахаар тогтсон болохыг та бүгдэд мэдээлж байна.

Д.Оюунтуяа: Бүрэнтогтохын хэлсэн саналтай холбоотойгоор тайлбар өгөх гэсэн юм. Баянхонгор, Говь-алтай аймгуудад бичил уурхай сайн хөгжсөн байдаг учраас хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагаанд саад учруулдаг. Бичил уурхай дээр талбайн дүгнэлт гэж гарахаа больсон, сонгон

шалгаруулалтын талбай гэж явдаг болсон учраас бичил уурхай эрхлэгчид лицензтэй компаниудын талбай руу дайрах явдал гардаг.

Б.Нэргүй: Наад асуудал чинь олон газар гарч байгаа. Ашигт малтмалын газраас яг энэ асуудлаар мэргэжлийн холбоод, компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтраад бодит байдал ийм байна, эрх зүйн орчин ийм байгаа гэх зэрэг байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хийвэл зүгээр байна. Оюунтуяа бичил уурхайн эрхлэгчдийн асуудлаар туршлагатай юм байна. Тэгэхээр өөрөө хариуцаад тийм ажил хийгээд ажлын хэсгийн дараагийн хуралдаан танилцуулаарай.

С.Бүрэнтогтох: Бичил уурхай эрхлэгчдээс гадна техникжсэн нинжа нарын асуудал нь уул уурхайн салбарын нэр хүндийг орон нутагт унагааж байна. Иргэд бол асуудлыг нөгөө хууль ёсны тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай холбож ойлгоод байдаг, яг газар дээрээ хэн байна вэ гэдгийг тандаад үзэхээр орон нутгийн удирдлагын зөвшөөрлөөр нөхөн сэргээлтийн гэрээ нэрэн дор олборлож буй техникжсэн нинжа нар байдаг. Эдгээр хүмүүс албан ёсны үйл ажиллагааг албан бус болгох зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Иймээс энэ асуудалд Уул уурхайн яам, холбогдох төрийн байгууллагууд анхаарал хандуулахыг хүсч байна.

Г.Чагнаадорж: Яг наад асуудал чинь компаниудын өөрсдийнх нь хийж байгаа ажил шүү дээ. Тухайлбал Монгол газрын Мянганбаяр техникжсэн нинжа гэж нэрлээд байгаа тийм улсуудыг цуглуулаад хууль бусаар алт олборлоод байдаг. МУУҮА ч юмуу, та бүгд компаниудын эрх ашгийг өмгөөлөлгүй яахав. Гэхдээ их нарийн ярьвал компаниуд өөрсдөө техникгүй байдаг юмуу, эсвэл ямар учиртай юм өөрсдөө тэр улсуудыг цуглуулж олборлуулдаг. Би үүнийг өнөөдөр ярьж байгаа юм биш. Их олон удаа ярьж байна. Наад асуудал чинь хаа саагүй газар авч байна. Заамар, Өвөрхангай, Архангай, Баянхонгор гээд хаа саагүй байна.

Б.Нэргүй: Чагнаадорж гуай бодитой л юм ярьж байна. Асуудлын гол нь бид өнөөдөр төлсөн, авсныг ил тодоор хэлэлцэж байна. Тиймээс сэдвээсээ хазайлгүй, ил тод байдлын асуудлаа л хэлэлцэе. Бүрэнтогтох түрүүнд бичил уурхай эрхлэгчдийн асуудлыг хөндсөн, тэр тухайд АМГ хамтраад арга хэмжээ зохион байгуулахаар сая тохиролцлоо шүү дээ. Баярсайхан, Оюунтуяа нар өөрсдийн зүгээс шийдвэрийн төслөө өгөөрэй. За ингээд дараагийн асуудалдаа орье.

III ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Хувиараа ашигт малтмал олборлогчдын асуудлаар Ашигт малтмалын газраас холбогдох мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хандсан үйл ажиллагаа зохион байгуулах, үр дүнг дараагийн Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахыг Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Оюунтуяад даалгав.

2. Монгол Улсын ОУИТБС-ын 2012, 2013 оны нэгтгэл тайланг Засгийн газрын 222-р тогтоолын дагуу УИХ-ын Эдийн засгийн болон төсвийн байнгын хороонд танилцуулах бэлтгэл ажлыг хангах тухай шийдвэрийн төсөл боловсруулж Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын алба /Ш.Цолмон/-д зөвлөв.

3. Иргэний нийгмийн эвсэл, олон улсын хараат бус судалгааны байгууллагуудаас зохион байгуулсан олон талт хэлэлцүүлэг, мониторинг, судалгаанаас гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх боломжийг судлах, авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий талуудын тэнцүү оролцоотой цомхон ажлын багийг шийдвэрийн 2.3-т заасан ажлын багтай хамтатган байгуулахаар тогтов.

IV ХЭЛЭЛЦСЭН нь: Европын сэргээн босголт банкны шугамаар туршлага судлах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Ш.Цолмон: Туршлага судлах аялалд хамрагдах бүрэлдэхүүнийг томилох асуудалтай холбоотойгоор МБОИЗ-өөс албан тоот ирсэн байна. Албан тоотыг уншиж танилцуулав /Албан тоотын хуулбарыг хавсаргав/.

Удаагаар Адам Смит Интернэйшнл байгууллагаас ирүүлсэн саналын дагуу Перу улс руу туршлага судлахаар болсныг, аялалын зорилго, ач холбогдлыг, түүнчлэн аялалын бүрэлдэхүүнд өгч буй ажлын албаны саналыг уншиж танилцуулав /танилцуулгыг хавсаргав/.

Б.Батболд: Иргэний нийгмийн төлөөллийг ТАН эвсэл, МБОИЗ гэсэн хоёр байгууллага төлөөлж ажилладаг. Миний хувьд ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт МБОИЗ-ийг төлөөлөн ажиллаж ирсэн. МБОИЗ-өөс туршлага судлах аялалын талаар албан тоот ирүүлсэн байна. Чагнаадорж ах бол ТАН эвслийг төлөөлж ажилладаг. Тиймээс МБОИЗ-ийг төлөөлж ажиллаж байгаа миний нэрийг дэвшүүлсэн шийдвэрийг хүндэтгэж буйгаа үүгээр мэдэгдэж байна.

Н.Баярсайхан: ТАН эвсэл ч гэсэн өөрсдийн шийдвэрээ эргэн харж, нэг хүнээ дахин танилцуулья.

Б.Баярмаа: ТАН эвсэл хуралдаад хэнийг явуулах шийдвэрээ гаргасан шүү дээ. Баярсайхан шийдвэрийг дагах хэрэгтэй.

Л.Долгормаа: Төрийн бус байгууллагууд бол ашгийн бус байгууллага, компаниуд бол ашгийн байгууллага, үйл ажиллагаа нь өөр өөр, гэтэл татвар авах болохоор яг ижил татвар ногдуулдаг. Бороо гоулд шиг баян компани иймэрхүү аялалд өөрсдөө зардлаа даагаад оролцох хэрэгтэй.

Х.Лхамаа: ОУИТБС-ын үйл ажиллагаанд талууд тэгш оролцдог. Ашиг олдог гээд компаниудыг зардлаа даагаад оролцох ёстой гэж үзэж болохгүй. Бид адилхан цаг зав гаргаад ОУИТБС-ын ажилд адилхан хүчин чармайлт гарган оролцдог. Тиймээс тэнцүү оролцоотой байх зарчимаа баримтлах хэрэгтэй. Бид өмнө нь олон удаа өөрсдөө зардлаа хариуцаж ирсэн.

Н.Дорждарь: Бороо гоулд ХХК-ийн хувьд зардлаа гаргах оролцох боломжтой шүү дээ. 5000 долларын л зардал гарах байх.

П.Болормаа: Компани бол бизнесийн байгууллага, энэ аялал бол туршлага судлах, ОУИТБС-ыг яаж илүү сайн хэрэгжүүлэх вэ гэж олон улсын туршлага судлах зорилготой. Тиймээс эдгээрийг ялгаж, салгаж ойлгох хэрэгтэй. Энэ удаагийн аялал нь нийгмийн шинж чанартай, зорилго бүхий аялал. Манай компани зардлаа хариуцаж оролцох боломж байхгүй, төсөв ч байхгүй.

Б.Нэргүй: 7 хүн болгож болох байлгүй дээ. Тийм боломж байгаа юу?

П.Оюунбилэг: ЕСБХБ-наас төрийг төлөөлж 2 хүн, компанийг төлөөлж 2 хүн, иргэний нийгмийг төлөөлж 2 хүн гээд нийтдээ яг 6 хүний зардлыг санхүүжүүлэх зардал төсөвлөсөн байгаа. Тиймээс бид илүү зардал гаргах бололцоогүй байгаа.

Г.Чагнаадорж: Миний хувьд иргэний нийгмийн төлөөлж олон жил ажиллаж ирлээ. Энэ хугацаанд их ч юм үзсэн. Батболд бол танхимд лекц уншаад ажилладаг бол би яг тэр уурхай дээр олон нийтийн төлөө тэмцэж ажилладаг. Гадаадын аялалд Батболд олон удаа явсан. Зарим аялалд бусаддаа боломж олгох хэрэгтэй. Намайг хөгшин гэж ялгаварлаж байгаа юмуу сайн ойлгохгүй байна.

Д.Энхболд: МУУҮА-ийн зүгээс аялалд явах Бороо гоулд ХХК-ийн татварын ахлах нягтлан бодогч Болормаа, Алт үйлдвэрлэгчдийн холбооны Бүрэнтогтох гэсэн төлөөллийг бүрэн дэмжиж байна.

Ч.Батчимэг: Сангийн яам, Татварын ерөнхий газар ОУИТБС-ын Засгийн газрын тайланг 7 жил гаргалаа. Энэ тайланг бэлтгэхэд их хүчин чармайлт гаргаж оролцдог. Тиймээс иймэрхүү туршлага судлах аялалд оролцуулах нь зүйтэй.

Б.Нэргүй: Миний хувьд нэрээ татахад татгалзах зүйл байхгүй, гэхдээ Уул уурхайн яамнаас энэхүү аялалын бүрэлдэхүүнд томилогдсон тул дангаар шийдвэр гаргах боломжгүй. Саналуудыг Отгочулуу даргад танилцуулъя. Төлөөллийг талуудын тэнцүү оролцоотой байхаар тогтоё. Харин ТАН эвсэл эргээд 1 хүний нэрээ өгөхөөр шийдвэрийн төслөө томъёолоод явъя. За ингээд өнөөдрийн хурлаа өндөрлөө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ЕСБХС-наас санхүүжүүлэн Адам Смит Интернэйшнл байгууллагаас зохион байгуулж буй туршлага судлах аялалын бүрэлдэхүүнийг талуудын тэнцүү төлөөлөлтэй байхаар шийдвэрлэв.

2. Компаниудыг төлөөлж туршлага судлах аялалд оролцох төлөөллийг компаниудын төлөөлөл бүрэн дэмжив.

3. Иргэний нийгмийг төлөөлж ТАН эвслээс туршлага судлах аялалд оролцох 1 төлөөлөгчийн нэрийг 10 дугаар сарын 15-ны 15:00 цагаас өмнө ажлын албанд хүргүүлэхээр тогтов.

4. Уул уурхайн яамны СБТГ-ын дарга Ч.Отгочулууд 10 дугаар сарын 13-ны өдрийн дотор төрийн байгууллагыг төлөөлөн туршлага судлах аялалд оролцох төлөөлөгчдийг дахин танилцуулж, эцэслэн шийдвэрлэхээр тогтов.

Хурал 12:30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУЯ-ны СБТГ-ын УУХ-ийн дарга

Б. Нэргүй

Тайврал хотоосон
УИТБСАА мэргэжилтэн

15